



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 05 сарын 14 өдөр

Дугаар A/83

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар Орос хэлний лингафоны сургалтын танхимын тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Н.Эрдэнэцэцэг

- Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Т.Бат-Эрдэнэ

-Ховд Их сургуулийн эдийн засагч

Б.Дэлгэрмаа

-Хувийн хэвшлийн төлөөлөл

Б.Казима

-Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Ж.Батлхагва

-Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Н.Эрдэнэцэцэг/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Ж.Батлхагва/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД